

Цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн заажээ.



Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” (С&Г 1:30) хэмээн Их Эзэн тунхагласан байдаг. Энэ сэргээгдсэн Сүм Аврагчийн Сүм учраас үнэн сүм юм. Аврагч бол “зам, үнэн, амь мөн” (Иохан 14:6). Ариун Сүнсний ажлууд ба бэлгүүдийн учир энэ нь амьд сүм юм. (Дэвид А.Бэднар, “Ариун Сүнсийг хүлээн авах нь,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 105)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүкс ийн заасан:



(1) Сургаалын бүрэн байдал, (2) санваарын хүч, (3) Есүс Христийн гэрчлэл гэсэн энэ гурван хүчин зүйл нь Бурхан яагаад үүнийг дэлхий даяарх цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм хэмээн тунхагласныг . . . тайлбарладаг. . . .

Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ нь ойлгомжтой, бүх нийтийн, нигүүлсэнгүй бөгөөд үнэн юм. . . .

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн удирдагчид болон зохих ёсоор эрх олгогдсон гишүүд санваарын хүчийг хүлээн авснаар баптисм хүртээх, Ариун Сүнсний бэлэг өгөх мөн ариун ёслолыг түгээх зэрэг шаардлагатай санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй болдог.

Бидний хайрт бошиглогч болон Сүмийн бусад бошиглогч, ерөнхийлөгч бүрийн атгадаг санваарын түлхүүрүүд нь түүнд Сүмийн өмнөөс илчлэлт хүлээн авах эрхийг олгодог. Бидний цаг үед шаардлагатай, Их Эзэний үгийг үргэлжлүүлэн дамжуулдаг бошиглогчид бидэнд байгаа учраас энэ Сүм “амьд” юм.

Яагаад цорын ганц үнэн Сүм болохын гурав дахь шалтгаан бол бидэнд Бурханы мөн чанарын тухай, Түүнтэй харилцах бидний харилцааны тухай илчилсэн үнэнүүд байгаа тул бидэнд Есүс Христийн өвөрмөц гэрчлэл бий. (Dallin H. Oaks, “The Only True and Living Church,” *New Era*, Aug. 2011, 3–5)